



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/248-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Т.Одсүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5.1 Төлбөрийн акт	22
5.3 Зөвлөмж.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЗГ	Засгийн газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МУЕА	Монгол Улсыг Ерөнхий Аудитор
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бар
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-25 № 00А-2023/048-НАСН-ГЧЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА, Н.МӨНХТУНГАЛАГ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан, анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг гүйцэтгэсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5, 20.2.6, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Сайхан сумын эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны А/17 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.2.1.1, 10.2.1.2 дахь заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

018020096²

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 8.3-т Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх ажлын хүрээнд анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт, хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хувьд хагас бие даасан тогтолцоонд шилжин ажиллах, тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалтын сахилга бат, хариуцлагыг чангатгах, эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоо бүрдүүлэх, хямд аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг бууруулах гэсэн чиглэлүүд өгөгдсөнтэй холбоотойгоор өмнөх онд орон нутгийн төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж байсан бол 2022 онд улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 53.7 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж, бараа материалын зардалд 41,399.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 396,485.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил үйлчилгээний зардалд 58,546.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10,862.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	673,484,046.73	434,941,815.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,041,304.41	290,223,377.17
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	4,041,304.41	290,223,377.17
31210	Төгрөг	4,041,304.41	290,223,377.17
31211	Төрийн сангийн харилцах	4,041,304.41	290,223,377.17
33	АВЛАГА	569,522,000.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	569,522,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	99,920,742.32	144,718,437.86
35100	Түүхий эд материал	76,813,990.32	113,659,441.86
35130	Эм боох материал	76,813,990.32	101,406,720.77
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	12,252,721.09
35400	Хангамжийн материал	23,106,752.00	31,058,996.00
35410	Бичиг хэргийн материал	-	2,250,040.00
35420	Аж ахуйн материал	5,263,210.00	19,308,109.00
35440	Түлш, шатах тослох материал	1,270,684.00	2,515,684.00
35460	Хүнсний материал	16,572,858.00	6,985,163.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	689,729,741.35	828,898,008.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	689,729,741.35	828,898,008.21
39200	Биет хөрөнгө	646,925,341.35	786,093,608.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	772,988,093.00	772,988,093.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(358,698,091.80)	(470,092,645.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	135,612,131.00	135,612,131.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(128,320,464.52)	(133,424,631.28)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	645,438,795.00	961,522,226.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(461,397,754.31)	(538,025,041.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,476,325.00	86,676,325.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,192,661.70)	(42,539,459.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,417,300.00	20,017,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,398,330.32)	(6,640,689.66)
39300	Биет бус хөрөнгө	42,804,400.00	42,804,400.00
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,804,400.00	42,804,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,363,213,788.08	1,263,839,823.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,222,435.00	21,246,355.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,222,435.00	21,246,355.36
41300	Өглөг	10,222,435.00	21,246,355.36
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	16,524,184.06
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,222,435.00	801,121.30
41360	Бусад өглөг	-	3,921,050.00

41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,921,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,352,991,353.08	1,242,593,467.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,352,991,353.08	1,242,593,467.88
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	757,270,416.00	757,270,416.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,076,614,137.25)	485,323,051.88
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,736,973,603.60)	(1,866,264,620.92)
51220	Тайлант үеийн үр дүн	660,359,466.35	679,252,598.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,672,335,074.33	1,672,335,074.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,363,213,788.08	1,263,839,823.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,836,237,358.00	2,681,243,869.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	92,062,501.00	1,683,429,658.98
120	Нийтлэг татварын бус орлого	92,062,501.00	1,683,429,658.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	813,146,720.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	49,184,914.00	740,508,672.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	42,877,587.00	129,774,266.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,744,174,857.00	997,814,210.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,578,800.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,145,578,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,024,933.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,356,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	779,724,933.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,944,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,477,700.00	226,316,926.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,477,700.00	226,316,926.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	632,093,424.00	771,497,284.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	632,093,424.00	771,497,284.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,175,877,891.65	2,001,991,271.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,175,877,891.65	2,001,991,271.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,083,965,241.65	2,001,991,271.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,582,265.75	1,013,539,895.98
210101	Үндсэн цалин	677,640,312.61	681,682,426.36
210102	Нэмэгдэл	294,155,976.89	265,486,232.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,231,000.00	11,514,000.00
210104	Урамшуулал	59,554,976.25	54,857,237.23

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,016,223.54	129,657,241.45
210201	Тэтгэврийн даатгал	105,923,011.00	94,185,396.38
210202	Тэтгэмжийн даатгал	8,501,200.00	9,109,322.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,800,999.85	6,914,346.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,369,704.64	1,661,146.81
210205	Эрүүл мэндийн даатгал	15,421,308.05	17,787,029.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,192,631.00	223,303,795.80
210301	Гэрэл, цахилгаан	18,933,036.00	15,998,934.94
210302	Түлш, халаалт	115,480,333.00	197,681,332.86
210303	Цэвэр, бохир ус	11,779,262.00	9,623,528.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,783,443.00	71,278,247.43
210401	Бичиг хэрэг	9,552,351.00	5,096,720.00
210402	Тээвэр, шатахуун	21,455,156.00	20,255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,463,556.00	3,041,537.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,317,000.00	2,467,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,995,380.00	40,417,990.00
2105	Нормативт зардал	461,435,041.01	231,601,385.82
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	354,986,367.01	191,571,500.82
210502	Хоол, хүнс	83,850,424.00	29,907,635.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,598,250.00	10,122,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,462,111.00	70,813,004.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,690,200.00	22,870,700.00
210604	Урсгал засвар	75,771,911.00	47,942,304.00
2107	Томилолт, зочны зардал	3,239,400.00	2,696,000.00
210702	Дотоод албан томилолт	3,239,400.00	2,696,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,622,104.00	42,453,236.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,666,030.00	40,828,661.38
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	86,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,479,099.00	1,289,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,632,022.35	216,648,464.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	10,933,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,132,022.35	205,715,164.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,912,650.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,900,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	85,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,012,650.00	-

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,650.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	660,359,466.35	679,252,598.47
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	660,359,466.35	679,252,598.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,174,652,857.00	2,384,524,235.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	817,188,024.41
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	813,146,720.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	813,146,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	813,146,720.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,174,652,857.00	1,567,336,210.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,578,800.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,145,578,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,024,933.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,356,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	779,724,933.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,944,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,477,700.00	226,316,926.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,477,700.00	226,316,926.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	62,571,424.00	1,341,019,284.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	62,571,424.00	1,341,019,284.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,093,295,852.59	1,800,196,358.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,093,295,852.59	1,800,196,358.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,001,383,202.59	1,800,196,358.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,582,265.75	997,015,711.92
210101	Үндсэн цалин	677,640,312.61	665,158,242.30
210102	Нэмэгдэл	294,155,976.89	265,486,232.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,231,000.00	11,514,000.00
210104	Урамшуулал	59,554,976.25	54,857,237.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,016,223.54	129,657,241.45
210201	Тэтгэврийн даатгал	105,923,011.00	94,185,396.38
210202	Тэтгэмжийн даатгал	8,501,200.00	9,109,322.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,800,999.85	6,914,346.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,369,704.64	1,661,146.81
210205	Эрүүл мэндийн даатгал	15,421,308.05	17,787,029.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,179,500.00	226,316,926.80

210301	Гэрэл, цахилгаан	18,933,036.00	15,998,934.94
210302	Түлш, халаалт	112,467,202.00	200,694,463.86
210303	Цэвэр, бохир ус	11,779,262.00	9,623,528.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,658,497.00	41,399,047.43
210401	Бичиг хэрэг	9,512,170.00	6,131,520.00
210402	Тээвэр, шатахуун	22,628,421.00	21,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,463,556.00	3,041,537.43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,677,140.00	3,226,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,377,210.00	7,499,990.00
2105	Нормативт зардал	488,442,000.30	231,321,501.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	366,382,500.30	201,225,561.06
210502	Хоол, хүнс	99,059,500.00	19,759,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,000,000.00	10,336,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,074,311.00	102,381,393.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,690,200.00	11,254,100.00
	Тавилга,		0.00
210604	Урсгал засвар	78,384,111.00	91,127,293.00
2107	Томилолт, зочны зардал	3,239,400.00	2,696,000.00
210702	Дотоод албан томилолт	3,239,400.00	2,696,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,691,005.00	58,546,236.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,666,030.00	55,592,661.38
210803	Даатгалын үйлчилгээ	160,000.00	160,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	78,675.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	87,775.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,548,000.00	2,639,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	10,862,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	10,862,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,912,650.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,900,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	85,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,012,650.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,012,650.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	81,357,004.41	584,327,877.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	77,315,700.00	294,104,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,315,700.00	294,104,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	77,315,700.00	294,104,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	77,315,700.00	294,104,500.00

210204	Ажилгүйдлийн даатгал	1,996,700.00	1,661,146.81	335,553.19	83.19
210205	Эрүүл мэндийн даатгал	19,967,700.00	17,787,029.65	2,180,670.35	89.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,588,800.00	226,316,926.80	12,271,873.20	94.86
210301	Гэрэл, цахилгаан	16,675,000.00	16,644,348.94	30,651.06	99.82
210302	Түлш, халаалт	202,547,400.00	200,694,463.86	1,852,936.14	99.09
210303	Цэвэр, бохир ус	19,366,400.00	8,978,114.00	10,388,286.00	46.36
2104	Хангамж, бараа материалын зардал	45,688,300.00	41,399,047.43	4,289,252.57	90.61
210401	Бичиг хэрэг	6,100,000.00	6,131,520.00	(31,520.00)	100.52
210402	Тээвэр, шатахуун	25,638,300.00	21,500,000.00	4,138,300.00	83.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,850,000.00	3,041,537.43	(191,537.43)	106.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,600,000.00	3,226,000.00	374,000.00	89.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,500,000.00	7,499,990.00	10.00	100.00
2105	Нормативт зардал	259,649,400.00	231,321,501.06	28,327,898.94	89.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	211,311,900.00	201,225,561.06	10,086,338.94	95.23
210502	Хоол, хүнс	38,000,000.00	19,759,140.00	18,240,860.00	52.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,337,500.00	10,336,800.00	700.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	526,148,800.00	396,485,893.00	129,662,907.00	75.36
210601	Багаж, техник, хэрэгсэл	354,780,000.00	277,978,700.00	76,801,300.00	78.35
210602	Тавилга	19,800,000.00	18,000,000.00	1,800,000.00	90.91
210604	Урсгал засвар	151,568,800.00	100,507,193.00	51,061,607.00	66.31
2107	Томилолт, зочны зардал	2,696,100.00	2,696,000.00	100.00	100.00
210702	Дотоод албан томилолт	2,696,100.00	2,696,000.00	100.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,882,200.00	58,546,236.38	24,335,963.62	70.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,640,500.00	55,592,661.38	24,047,838.62	69.80
210803	Даатгалын үйлчилгээ	260,000.00	160,000.00	100,000.00	61.54
210804	Тээврийн хэрэгслийн татвар	229,200.00	78,675.00	150,525.00	34.33
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,500.00	0	37,500.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,640,000.00	2,639,900.00	100.00	100.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,300,700.00	10,862,300.00	310.00	62.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,300,700.00	10,862,300.00	6,438,400.00	62.79
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,401,157,100.00	2,380,482,930.80	-20,674,169.20	110.08
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,588,800.00	226,316,926.80	12,271,873.20	94.86
320001	Орон нутгийн төсвөөс	238,588,800.00	226,316,926.80	12,271,873.20	94.86
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,348,881,500.00	1,341,019,284.00	7,862,216.00	99.42
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,348,881,500.00	1,341,019,284.00	7,862,216.00	99.42
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	813,686,800.00	813,146,720.00	540,080.00	99.93
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	813,686,800.00	813,146,720.00	540,080.00	99.93
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	290,223,377.17	(290,223,377.17)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66.00	52.00	14.00	257.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	51.00	40.00	11.00	78.43
620003	Үйлчлэх ажилтан	14.00	11.00	3.00	78.57
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	66.00	52.00	14.00	78.79
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	52.00	41.00	11.00	78.85
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	11.00	3.00	78.57



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төв нь (цаашид Сайхан сумын Эрүүл мэндийн төв гэх) “Мэргэжилтнээ дэмжиж, үйлчлүүлэгчээ хүндэтгэн, ерөнхий болон үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээг орчин үеийн нотолгоонд тулгуурласан чадварлаг багаас бүрдсэн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, сувилгааны хариуцлагатай, ээлтэй, тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т “Сум, тосгоны эрүүл мэндийн төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна” гэж заасан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтийг батлагдсан өдрөөс буюу 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоолд 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2021 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” журам хэрэгжсэн.
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө(2021-2023 он)
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаалаар батлагдсан “(Ковид-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн.

- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/355 дугаар тушаалаар батлагдсан “Бүртгэл, тайлангийн маягт шинэчлэн батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн.
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 12-1/981 дүгээр “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл өгсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,374.0 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,041.3	290,223.4	286,182.1
Авлага	569,522.0	-	(569,522.0)
Бараа материал	99,920.7	144,718.4	44,797.7
Үндсэн хөрөнгө	689,729.7	828,898.0	139,168.3
Нийт хөрөнгө	1,363,213.8	1,263,839.8	(99,374.0)
Өр төлбөр	10,222.4	21,246.4	11,023.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,352,991.4	1,242,593.5	(110,397.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,363,213.8	1,263,839.8	(99,374.0)

Мөнгөн хөрөнгө данс 290,223.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тайланд онд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүждэг болсонтой холбоотойгоор төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл 569,522.0 мянган төгрөг байсан бол оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан нь ЭМДС-аас авах (Ковид-19) цар тахлын дутуу санхүүжилтийг бүрэн авсантай холбоотой байна.

Бараа материалын данс 144,718.4 мянган төгрөг болж 44,797.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 362,586.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, аймгийн ЭМГ-аас (Ковид-19) цар тахлаас хамгаалах нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, болох, нүдний шил, нэг удаагийн халаад, нүүрний хаалт, улавч, хормогч, үзлэгийн бээлий, вирусийн эм зэрэг 29,853.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон байгууллагын үйл ажиллагаанд 347,642.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,019,870.4 мянган төгрөг болж өмнөх оноос 344,883.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 294,104.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил /компьютер, хэвлэгч төхөөрөмж, амьсгалын аппарат, био химийн анализатор, гадна гэрэл, сүүдрэвч, зөөврийн рентген аппарат, ор, шүүгээ, унтуулгын аппарат, барианы ор, цахилгаан соронзон төөнүүр, цахилгаан зүүний аппарат/ худалдан авсан болон ЭМЯ-аас 5,617.6 мянган төгрөгийн, аймгийн ЭМГ-аас 45,161.3 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авснаас тус тус шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 21,246.4 мянган төгрөг болж 11,023.9 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны 16,524.2 мянган төгрөг, тендерийн эмийн /Тавин-ус ХХК-98.5 мянган төгрөг, Айвико ХХК-23.8 мянган төгрөг, Монос трейд ХХК-81.0 мянган төгрөг, Нахиа ХХК-96.3 мянган төгрөг, Эм импекс концерн ХХК-415.9 мянган төгрөг, Сүвэн-Уул ХХК-85.6 мянган төгрөг / байгууллагуудад

төлөх 801.1 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангаас /Энто ХХК-777.5 мянган төгрөг, Монос Дархан ХХК-1,423.2 мянган төгрөг, Эм импекс концерн ХХК-1,720.3 мянган төгрөг/харилцагч байгууллагуудад дутуу шилжүүлсэн 3,921.0 мянган төгрөгийн өр төлбөрүүдийг барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,242,593.5 мянган төгрөг болж 110,397.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлын ЭМДС-аас санхүүжих дүнг 1,448,863.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 238,321.2 мянган төгрөгөөр тооцож нийт 1,687,452.4 мянган төгрөгийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 1,687,452.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт зохицуулалт хийж 713,704.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 58,229.7 мянган төгрөгөөр
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 22,304.2 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 129,663.0 мянган төгрөгөөр,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 85,406.0 мянган төгрөгөөр,
- Норматив зардлыг 115,89.4 мянган төгрөгөөр,
- Тавилга эд хогшил, урсгал засварын зардлыг 480,818.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 78,451.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Дотоод албан томилолтын зардлыг 887.0 мянган төгрөгөөр
- Хангамж бараа материалын зардлыг 1,965.1 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 39,145.6 мянган төгрөгөөр тус тус бууруулан ЭМДС-аас санхүүжих дүнг 1,348,811.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүн 813,686.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 238,588.8 мянган төгрөг нийт 2,401,157.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 2022 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн.

Гүйцэтгэлээр ЭМДС-аас 1,341,019.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 226,316.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 813,146.7 мянган төгрөг зэрэг нийт 2,380,482.9 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 2,090,259.6 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 290,223.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,090,259.6 мянган төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь санхүүжилтийн гүйцэтгэл болон үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийн 310,897.5 мянган төгрөгийн хэмнэлтээс тус тус шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ	80302-Нэг иргэнд ногдох	417,651.6	407,682.9	9,968.7	97.6
2		81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	931,229.9	803,134.1	128,095.8	86.2
3		80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	238,588.8	226,316.9	12,271.9	94.9
4		83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	813,686.8	653,125.6	160,561.2	80.3
Дүн			2,401,157.1	2,090,259.6	310,897.5	87.1

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл


Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх, эрүүл мэндийн салбарын ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,178,877.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 21,758.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 85,406.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 20,165.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,272.0 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардлыг 4,289.3 мянган төгрөг, нормативт зардлыг 28,327.9 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 129,662.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил үйлчилгээний зардлыг 24,336.1 мянган төгрөг, бусад зардлыг 6,438.4 мянган төгрөг зэрэг нийт **310,897.5** мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 22 төрлийн 191 мэдээллээс 39 мэдээллийг хугацаа хоцроож, 62 мэдээллийг огт мэдээлээгүйгээс гадна цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн

дүн бүхий орлого, зарлагын мөнгө гүйлгээний мэдээллийг 7 дугаар сараас хойш огт мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.10 дахь заалтуудыг зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд


1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ", 48.5-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байх зөвлөмж өгөв.

2. Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарын онцлогт тохирохгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЭМЯ-ны төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх зөвлөмж өгөв.



4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэлийг тодорхойлж, аудитаар 569,522.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажилтнуудын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг олгосон, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,428.9	1	1,428.9	100.0
Албан шаардлага	1	4,902.9	1	4,902.9	100.0
Зөвлөмж	4	229,912.4	1	1,933.0	25.0
Нийт дүн	6	236,244.2	3	8,264.8	50.0

Өмнөх онд өгөгдсөн албан хаагчдын ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэсний үндсэн дээр нэмэгдлийг сар бүр олгоогүй, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Албан хаагчдын 1, 2, 3 дугаар улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгохдоо цалингийн тооцооллын алдаа гаргаж үндсэн цалингаас бус бодогдсон цалингаас тооцож 6,606.4 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг дутуу олгосон байна

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.2 дахь

“Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Цаашид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг үндсэн цалингаас тогтоосон хувь хэмжээгээр тооцон, үнэн зөв бодож олгож байх нь зүйтэй юм.

2.Шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журмыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор баталсан боловч зарцуулалт, тайлагнал, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байхад санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, цалинг гүйцэтгэл, үр дүнд суурилан нэмэгдүүлэх гэх үндэслэлээр дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр буюу Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны Б/91 дүгээр тушаалаар үндсэн цалингийн доод жишгийг 11 дүгээр сараас эхлэн 78-271 хувиар нэмэгдүүлснээс шалтгаалан 11, 12 дугаар сард нийт **143,833.2** мянган төгрөгийг цалин хөлс, нэмэгдэлд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг, төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” журмын 2 дахь “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг салбарын онцлог болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдүүлж олгох асуудлыг зохицуулахад чиглэсэн арга хэмжээг батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг **төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй**”, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” журмын 8.3.5 дахь “Төсвийн хувьд хагас бие даасан тогтолцоонд шилжин ажиллах,тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалтын сахилга бат, хариуцлагыг чангатгах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид цалингийн доод жишгийг эрүүл мэндийн салбарын ТЕЗ-ийн албан ёсны шийдвэрийг үндэслэн нэмэгдүүлж байх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **446,117.7** мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл дутуу байгуулсан, дансны бичилт буруу хийсэн, үндсэн хөрөнгийн орлого дутуу бүртгэсэн зэрэг алдааг залруулав. Үүнд.

- Дотоод албан томилолтыг урьдчилгаа дансаар бус өглөгийн дансаар дамжуулсан 2,696.0 мянган төгрөг,
- Бараа материалын дансанд нэр төрлөөр бус бөөн дүнгээр орлого авсан 5,676.7 мянган төгрөг,
- Тавилга эд хогшлын дансанд машин тоног төхөөрөмж бүртгэсэн 829.9 мянган төгрөг,

